

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА С.ЦЭДЭНСОДНОМ

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 13, 14 ДҮГЭЭР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХИЙГДЭХ ГЭР
ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН "Д" ХЭСЭГЧИЛСЭН ТАЛБАЙН ӨНДӨР
ХҮЧДЭЛИЙН ШУГАМ СҮЛЖЭЭГ ЗӨӨХ АЖИЛ (БЗД, 13, 14 ДҮГЭЭР ХОРОО)-ЫН
ДААЛГАВАР**

2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Дугаар № 2024/64 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/624 дугаар захирамж.- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн 2024 сарын 08 дугаар сарын 26-ны өдрийн 04/397 тоот албан бичиг
2.	Барилга байгууламжийн байршил	<ul style="list-style-type: none">- Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хороо
3.	Зориулалт хүчин чадал	<ul style="list-style-type: none">- Цахилгаан дамжуулах агаарын шугам буулгаж кабель шугам татах
4.	Төслийн гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none">- Захиалагч, гүйцэтгэг талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5.	Төслийн иж бүрдэл	<p><u>Баримт бичгийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none">- Техникийн нөхцөл- Зургийн тодруулга <p><u>Зураг төсвийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none">- Нүүр хуудас /Батлагдсан байх/- Гадна шугам сүлжээний зураг /Холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн байх./- Зураг төсөв /Магадлалаар батлагаажсан байх/
6.	Зураг төсөл боловсруулах үе шат	<ul style="list-style-type: none">- Ажлын зураг төсөв нэг үе шаттай:- Ажлын зураг, төсөв боловсруулж, батлуулах;
7.	Зураг төслийн байгууллага	Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл, угсралт засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ын Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд;
8.	Захиалагч байгууллага	<ul style="list-style-type: none">- Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
9.	Засвар хийгдэх ажлууд	<ul style="list-style-type: none">- 10 кВ-ын Төмрийн завод фидерийн тулгуур №9-12-ыг буулгаж цахилгаан дамжуулах кабель шугам татах

		<ul style="list-style-type: none"> - Буулгасан тулгууруудыг харьяа эзэмшигч байгууллагад хүлээлгэж өгөх
10.	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Цахилгааны шугам эзэмшигч байгууллагаас техникийн нөхцөл хүсэх. - Батлагдсан техникийн нөхцөлийн дагуу зураг төсөв, угсралтын ажил гүйцэтгэх. - Зураг төсвийг Монгол улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД 43-101-03 дагуу боловсруулах. - Зураг төсөлд дэвсгэр зураг ашигласан байх. - Зураг төслийн трассыг харьяа байгууллагад хүлээлгэн өгөн мэдээллийн сан болон нийслэлийн мэдээллийн санд бүргүүлэх. - Кабель шугамыг туршилт явуулах эрх бүхий байгууллагад мөрдөгдөж буй стандартын дагуу гүйцэтгэсэн нэг маягийн туршилтад хамрагдсан болохыг нотолсон баримт баталгааг гаргасан байх. - Кабель шугамын цахилгаан эсэргүүцэл, бяцхан цахилгалтын туршилт, хувьсах гүйдлийн өндөржүүлсэн хүчдэлийн туршилт хийлгэсэн байх. - Кабель шугамыг угсрахдаа Монгол улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД 43-101-03 дагуу угсарсан байх. - Кабель шугам нь хийцийн хувьд хэмжээ ижил жигд, чанарын хувьд зөөлөн, уяан хатан цул шинж чанартай ба хурц ирмэг бусад гэмтэл дефектгүй байх шаардлагатай. - Кабель шугам нь тусгаарлагч бүрхүүлтэй байна - Кабель шугамын бүрхүүл нь тусгаарлагдсан, ус чийг нэвтрүүлэхгүй, хүчил ба шүлт, нарны гэрэл ба галд тэсвэртэй байна. - Кабель шугамын ашиглалтын хугацаа өндөр байх. - Кабель шугамд ашиглаж буй дундын ба үзүүр муфт нь гэмтэл дефектгүй байх. - Муфтны дотуур дамжуулагч утас сүвлэхэд тохиромжтой байх. - Муфтны дотор ус чийг нэвтэрхээргүй битүүмжлэгдсэн байх. - Угсралт хийх үед харьяа байгууллагын хяналтан доор гүйцэтгэх.
11.	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Хууль тогтоомж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний тухай хууль - Барилгын тухай хууль <p><u>Норм. нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Эрх бүхий байгууллагын техникийн нөхцөл - Монгол улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД 43-101-03 - Техник ашиглалтын дүрэм

		<ul style="list-style-type: none"> - Аюулгүй ажиллагааны дүрэм - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм; - Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтанд оруулах дүрэм - Цахилгаан техникийн ажил /БНБД 3.05.06-90/ - Барилга засварын ажлын төсвийн суурь нормууд - Бусад холбогдох норм, дүрэм;
12.	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНБД 21.02.02/ - Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/
13.	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> - Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗТХ-ИЙН ДАРГА

...../Б.ЛХАГВАЖАВ/ -2

БОЛОВСРУУЛСАН:
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

...../Э.ЭНХТӨГӨЛДӨР/